

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр: Багануур Хувьцаат Компани

Хаяг, утас: Улаанбаатар хот, Багануур дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн хэсэг, Өөрийн байр
Утас: 7021-0114; 7021-3739

Хурал хуралдах огноо, цаг, газар:
2015 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 14.00 цагт
Улаанбаатар хот Багануур дүүрэгт орших Багануур ХК-ийн
хурлын танхимд

Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо:
Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 03 дүгээр сарын 13-ны
өдрийн 05 тоот тогтоол

Олон нийтэд зарлах огноо:
2015 оны 03 дүгээр сарын 18-ны өдөр

Бүртгэх өдөр 2015 оны 03 дугаар сарын 30-ны өдөр

Гэрээний дагуу хурлын баримт бичгийг брокер дилерийн компанид хүргүүлэх огноо

Хүргүүлсэн огноо

Хурлын баримт, бичгийн хуудасны тоо 3 ширхэг 9 хуудас

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ
КОМИССЫН ДАРГА /Л.ШАГДАРСҮРЭН/

2015 оны 03 дүгээр сарын 16-ны өдөр

ХҮЛЭЭН АВСАН:
БҮРТГЭЛИЙН МЭРГЭЖИЛТЭН

2015 оны 03 дүгээр сарын ... -ны өдөр

“БАГАНУУР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

“Багануур” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2015 оны 04-р сарын 29-ний өдрийн 14 цагт Багануур дүүрэгт байрлах тус компанийн төв байрны хурлын танхимд болно.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэнэ. Үүнд:

- Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах
- Санхүүгийн тайланд хийсэн хараат бус аудитын дүгнэлт
- Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны дүгнэлт
- Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны үйл ажиллагааны тайлан болон 2015 оны зардлын төсөв
- Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай
- Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийн сонгох

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2015 оны 03 дугаар сарын 30-ны өдрөөр тасалбар болгоно.

Эрх бүхий хувьцаа эзэмшигчид 2015 оны 04 дүгээр сарын 07-ны өдрөөс эхлэн хурал хуралдахаас нэг хоногийн өмнөх хүртэл хугацаанд ажлын өдрүүдэд Багануур ХК-ийн захиргааны байрны 104, 203 тоот өрөө болон Улаанбаатар хот дахь Төлөөлөгчийн газрын байранд очиж “Танилцаж болох баримт бичиг”-тэй танилцаж болно.

Санал хүлээж авах сүүлчийн өдөр: 2015.04.28-ны өдрийн 14.00 цаг

Хурал зохион байгуулах комисстой холбоо барих утас:

Комиссийн дарга: 70213739, 99119714

Гишүүд: 88082547, 99044373

BJSC@baganuurmine.mn

Эрхэм хувьцаа эзэмшигч Та бүхнийг хуралдаа хүрэлцэн ирэхийг урьж байна.

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС



“БАГАНУУР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2015 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 05

Багануур

Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.3 дах заалт, Багануур ХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Багануур ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2015 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 14 цагт Монгол Улс, Улаанбаатар хот, Багануур дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн хэсэгт байрлах Багануур ХК-ийн хурлын танхимд хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар дор дурьдсан асуудлыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:
 - 2.1 Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах
 - 2.2 Санхүүгийн тайланд хийсэн хараат бус аудитын дүгнэлт
 - 2.3 Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны дүгнэлт
 - 2.4 Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны үйл ажиллагааны тайлан болон 2015 оны зардлын төсөв
 - 2.5 Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай
 - 2.6 Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
3. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2015 оны 03 дугаар сарын 30-ний өдрөөр тогтоосугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд хурлын тов, байршил, хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, бүртгэлийн өдөр, хурал зохион байгуулах комиссын талаарх мэдээлэл бүхий зарыг 2015 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн дотор өдөр тутмын хоёроос доошгүй сонинд нийтлүүлж, “Хөрөнгийн бирж” ХК-ийн цахим хуудсанд байршуулсугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг энэ тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар, хурлаар хэлэлцэх асуудлаар “Санал авах хуудас”-ны загварыг гуравдугаар хавсралтаар, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох “Санал авах хуудас”-ны загварыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
7. Эрх бүхий хувьцаа эзэмшигчид 2015 оны 4 дүгээр сарын 07-ны өдрөөс эхлэн хурал хуралдахаас нэг хоногийн өмнө Багануур ХК-ийн албан ажлын байр болон Улаанбаатар хот дахь Төлөөлөгчийн газрын байранд очиж танилцаж болох баримт бичигтэй танилцах эрхтэй болохыг дурьдсугай.

8. Хувьцаа эзэмшигч нь ээлжит хурлаар хэлэлцэх асуудлаар саналын хуудсаар урьдчилан санал өгч болох бөгөөд саналын хуудсыг хүлээн авах газар, сүүлчийн хугацааг доорх байдлаар тус тус тогтоосугай. Үүнд:
- 8.1 Саналын хуудас хүлээн авах газар: Улаанбаатар хот, Багануур дүүрэг, 3-р хороо, Үйлдвэр хэсэгт байрлах Багануур ХК-ийн байр 207, 412 тоот өрөөнд тооллогын комисс хүлээн авна.
- 8.2 Саналын хүлээн авах хугацаа “Саналын хуудас” –ыг хүлээн авах сүүлчийн өдрийг харьяалагдах брокер диллерийн компаниар дамжуулан хурал хуралдах өдрөөс нэг хоногийн өмнө байхаар тогтсугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга нь компанийн нийт хувьцааны 75 хувийн хувьцааг эзэмшигч “Эрдэнэс Монгол” ХХК-иас хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал гаргах эрхтэйгээр томилогдсон этгээд байхыг дурьдсугай.
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зохион байгуулах комиссыг дор дурьдсан бүрэлдэхүүнтэй баталсугай.

Хурал зохион байгуулах комиссын дарга

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Гишүүд

Хуулийн зөвлөх

Сургалтын мэргэжилтэн

Хэвлэл мэдээллийн ажилтан

Захиргааны зохион байгуулагч

Л.Шагдарсүрэн

Д.Ганчимэг

Ж.Дашцэрэн

С.Одончимэг

Б.Соёлмаа

11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссыг дор дурьдсан бүрэлдэхүүнтэй баталсугай.

Тооллогын комиссын дарга

Дотоод хяналт шалгалтын албаны дарга

Гишүүд

Гэрээний ажилтан

Эдийн засагч

Д.Түвшинтөгс

Б.Наранцэцэг


Д.Даваадаш

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.ДАМБА




Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны
03 дугаар сарын 13 өдрийн 45 тоот
тогтоолын нэгдүгээр хавсралт



"Багануур" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг

Д/д	Хурлын дэг	Хугацаа, цаг минут
1.	Хурлын ирц бүртгэх /Тооллогын комисс/	13.00-14.00 цагт
2.	Хурлын ирц мэдээлэх /Зохион байгуулах комисс/	5 минут
3.	Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргыг сонгох	5 минут
4.	Хурлын дарга хурлын ажиллагааг нээж хурлаар хэлэлцэх асуудал, хурлын дэгийг танилцуулах	10 минут
5.	Хэлэлцэх асуудлыг дарааллын дагуу танилцуулж хэлэлцүүлэх	Асуудал тус бүрээр 30 хүртэл минут
6.	Хуралд оролцогсдын асуулт хариулт, санал дүгнэлт авах	Хүн тус бүрээр 5 мин
7.	Завсарлага	15 мин
8.	Тооллогын комиссын тогтоолыг танилцуулах	5 мин
9.	Хурлаас гарах шийдвэр тогтоолын төслийг танилцуулах	15 мин
10.	Хурлын ажиллагааг хаах	5 мин

Хурал зохион байгуулах комисс




Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны
03 дугаар сарын 14 өдрийн 11 тоот
тогтоолын хоёрдугаар хавсралт

“Багануур” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар
хэлэлцэх асуудалтай холбогдох танилцаж
болох баримт бичгийн жасгаалт

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах
2. Санхүүгийн тайланд хийсэн хараат бус аудитын дүгнэлт
3. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны дүгнэлт
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны үйл ажиллагааны тайлан болон 2015 оны зардлын төсөв
5. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах төсөл

Хурал зохион байгуулах комисс

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны
03 дугаар сарын 14 өдрийн 05 тоот
тогтоолын гуравдугаар хавсралт



Багануур ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлаар
Санал авах хуудас

Хувьцаа эзэмшигчийн овог нэр

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар

--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

Хувьцаа эзэмшигчийн регистрийн дугаар

--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

Санал өгөх хувьцааны тоо

Бүртгэсэн /брокер, диллерийн компани/

Брокерийн овог нэр

Багануур ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2015 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 14 цагт Багануур ХК-ийн хурлын танимд болно.

№	Хэлэлцэх асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан			
2	Санхүүгийн тайланд хийсэн хараат бус аудитын дүгнэлт			
3	Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны дүгнэлт			
4	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны үйл ажиллагааны тайлан болон 2015 оны зардлын төсөв			
5	Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах төсөл			


Брокерийн/...../

гарын үсгийн тайлал

Хувьцаа эзэмшигчийн/...../

гарын үсгийн тайлал

2015 оны сарын-ны өдөр



Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн тогтоолын дөрөвдүгээр хавсралт

Багануур хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар ТУЗ-ийн гишүүдийг сонгох Санал авах хуудас

Хувьцаа эзэмшигчийн овогнэр.....
 Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар:

--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

Хувьцаа эзэмшигчийн регистрийн дугаар:

--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

Санал өгөх хувьцааны тоо:.....Кумулятив саналын тоо

Бүртгэсэн / брокер, диллерийн компани /.....
 Брокерийн овогнэр.....

Багануур хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2015 оны 04 дүгээр сарын 29 –ний өдрийн 14.00 цагт Багануур хувьцаат компанийн хурлын танхимд болно.

	ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийн овог нэр	Нэр дэвшигчид өгөх саналын тоо
	Ердийн гишүүн	
1		
2		
3		
4		
5		
6		
7		
8		
9		
	Хараат бус гишүүн	
1		
2		
3		

Брокерийн / /
 гарын үсгийн тайлал
 Хувьцаа эзэмшигч..... / /
 гарын үсгийн тайлал

2015 оны –р сарын өдөр

ТУЗ-ийн гишүүдийг сонгох санал хураалтыг кумулятив аргаар хураана.
Кумулятив арга нь санал өгөх эрхийн нийт тоо таны эзэмшиж байгаа саналын эрхтэй энгийн хувьцааны тоог сонгогдох гишүүний тоогоор үржүүлсэнтэй тэнцүү байна.

Жишээ нь: Та 100 ширхэг энгийн хувьцаа эзэмшдэг гэвэл тус компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй байхад түүнээс 3 гишүүн нь хараат бус гишүүн байхаар тооцоолсон тохиолдолд хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй 100 ширхэг хувьцаа нь 900 саналын эрхтэй / $100 \times 9 = 900$ / болох бөгөөд үүнээс 600 саналын эрхээрээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 саналын эрхээрээ ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус саналаа өгөх эрхтэй болно.

Саналын хуудасыг ашиглах санамж:

1. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй тохиолдолд зуучлагч брокерийн компани дээр очиж хурлын материалтай танилцаж "Санал авах хуудас"-аар саналаа өгнө.
2. Засварласан болон балласан, залруулгатай "Санал авах хуудас" хүчингүйд тооцогдоно.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын талаархи мэдээллийг 263963 дугаарын утсаар авч тодруулж болно.
4. "Санал авах хуудас" хүчингүй болсон тухай шалтгаан

.....
.....
.....
.....

2015 оны –р сарын өдөр